



**AMERICAN
SCHOOL**
of ULAANBAATAR
Learn * Achieve * Lead

**Ахлах, Дунд Сургуулийн Эцэг Эх, Сурагчдын
Мөрдөх Журам
2017-2018**

*Хан-Уул дүүрэг, Зайсангийн 11-р хороо
Шуудангийн хайрцаг 2365, Төв шуудан
Улаанбаатар, 15160 Монгол Улс
Утасны дугаар: (976-11) 348888
Факсын дугаар: (976-11) 345359
www.asu.edu.mn*



Эрхэм зорилго

Улаанбаатар дахь Америк Сургууль нь насан туршийн боловсролыг эрхэмлэдэг хамт олон юм. Бид сурагч бүрт Олон Улсын жишигт нийцсэн боловсролын таатай орчинд, сурлагын өндөр амжилт гаргах бүхий л боломжоор ханган ажилдаг. Сурагчдаа англи хэлээр боловсрол олгодог гадаадын их дээд сургуулиудад дэвшин суралцахад нь бэлтгэж, улмаар тэднийг оюунлаг, манлайлагч, ёсзүйтэй, бие бялдарын хувьд эрүүл чийрэг иргэн болж төлөвших чадварыг эзэмшүүлэхэд бид түлхүү анхаардаг.

Хэтийн төлөв

Улаанбаатар дахь Америк Сургууль нь сурагчдынхаа оюун ухаан, бие бялдар, авъяас чадварыг бүрэн идэвхтэй нээж, хөгжүүлэхэд бүрэн дэмжлэг болохуйц сургалтын таатай орчинг бүрдүүлнэ. Бид сургалтын үндсэн болон туслах хөтөлбөрүүдээр дамжуулан даяаршиж буй өнөөгийн нийгэмд хүүхдийг амжилттай сурч, боловсрох чадвартай, өв тэгш хөгжүүлэхийн төлөө чармайн ажиллана.

Сургалтын түвшинд тавигдах зорилго (ESSO's)

Сурч боловсрохыг эрмэлзэгч байх...

- Олж авсан мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан өөрийн зорилгыг ухамсартайгаар тодорхойлох
- Бие даан идэвхтэй сурч боловсрох
- Сайн суралцахын тулд өөртөө байнга хяналт тавьж үнэлгээ, дүгнэлт өгөх

Бүтээлчээр сэтгэгч байх...

- Төрөл бүрийн сувгаар мэдээллийг олж авч, дүн шинжилгээ хийн, боловсруулах чадвартай байх
- Асуудлыг шийдэх, шийдвэр гаргах, зөрчилдөөнийг зохицуулах чадвартай байх
- Олсон мэдлэгээ амьдралд хэрэгжүүлдэг байх

Нийгмийн идэвхтэй иргэн байх ...

- Хүрээлэн буй орчин, хамт олондоо санаа тавих
- Соёлын ялгаа бүхий хүмүүсийг хүндэтгэх, хамтран ажиллах чадвартай болох
- Бусдын эрх ашгийг хүндэтгэдэг байх
- Өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд анхаарал тавьдаг байх

Харилцааны өндөр чадвартай байх ...

- Төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан мэдээллийг уншиж, бичиж, сонсож, ойлгох болон дамжуулах чадвартай байх
- Техник технологийг үр ашигтайгаар хослуулан ашигладаг байх
- Ойлгох, эргэцүүлэн бодох чадвараа сайжруулахын тулд бусдыг анхааралтай сонсож, асуулт тавих
- Хамтын зорилгодоо амжилттай хүрэхийн тулд сургалтын аливаа арга хэмжээ, төсөлт ажил дээр багаар хамтран ажиллаж сурах

Насан туршдаа өөрийгөө дайчлагч, суралцагч байх ...

- Сурч боловсрох үүрэг, хариуцлагаа ойлгож ухамсарлах
- Сурах зорилгоо тодорхойлж, дэс дараатай хөгжүүлэн, шинэчлэн өөрчилдөг байх
- Өөрийгөө боловсруулах, сорих шинэ боломжуудыг эрэлхийлдэг байх
- Зорилгоо тодорхойлох, цагаа зөв төлөвлөх, хувийн зохион байгуулалтаараа өрсөлдөх чадвартай.

Сургалтын Бодлого

Улаанбаатар дахь Америк Сургууль нь сурагч бүрт дээд зэргийн чанартай, өндөр түвшний сургалтын орчинг бүрдүүлэх зарчим баримтална. Үүний тулд бид сурагчдын сурлагыг ахиулах, сургалтын явцын талаар нарийн мэдээллээр хангах зорилго бүхий дүн үнэлгээний загварыг боловсруулж гаргасан. Улаанбаатар дахь Америк Сургуулийн хичээлийн жил 2 семестерт хуваагдана. Эцэг эхчүүдэд сурагчийн сурлагын ахиц, амжилтын талаар тухай бүр мэдээлэл өгдөг. Гэрийн даалгавар, төсөлт ажил, дадлагын ажил, илтгэл, тест, асуулт хариулт, албан ёсны шалгалт гэх мэт шалгуураар сурагчдыг үнэлж, дүгнэнэ. Ахлах ангийн сурагчдаас семестер бүрийн төгсгөлд шалгалт авна.

Хичээлээ шударгаар хийх

Сургууль нь сурагчийг хичээл, даалгавар хийхдээ үнэнч, шударгыг чандлан эрхэмлэж, хийж гүйцэтгэсэн даалгавар дээрээ ашигласан материал, эх сурвалжаа тодорхой бичдэг байхыг шаардана. Хичээлдээ бусдын бүтээлээс ашигласан, хуулсан, шалгалтан дээр хуулсан сурагчид даалгавраа дахин хийхийг шаардах бөгөөд хэрэв энэхүү үйлдэл давтагдвал сурагчийг сургуулиас бүрмөсөн гаргах хүртэл арга хэмжээ авна.

Хичээлийн дүн, үнэлгээ

Сурагчийн сургалтын дүн, хичээлийн явц, ололт амжилтыг эцэг эхчүүд болон сурагчдад цаг тухайд нь илтгэж, мэдээлж байхыг бид ямагт эрхэмлэнэ. Хичээлийн жилийн явцад, нийт хоёр удаа, семестр бүрт дүн гарах бөгөөд, сурагчдын сурлага, хичээлийн явцыг эцэг эхчүүдэд зориулсан Parent Portal-аас авах боломжтой. Уг сайт руу хэрхэн нэвтрэх зааврыг Сургалтын Албанаас авна.

Дүн

Сурагчийн ирц хичээлд авах нийт дүнгийн 10%-тай (хамгийн багадаа) дүйцэх бөгөөд дүнгийн задаргааг доор харуулав:

A+ = 97- 100%
A = 93 - 96%
A- = 90 - 92%
B+ = 87 - 89%
B = 83 - 86%
B- = 80 - 82%
C+ = 77 - 79%
C = 73 - 76%
C- = 70 - 72%
D+ = 67 - 69%
D = 63 - 66%
D- = 60 - 62%
F = <60%

Анги дэвших

Дунд сургууль (6-8-р анги): Хоёр буюу түүнээс дээш голлох хичээл дээр (Математик, Англи хэл, Шинжлэх ухаан, Нийгэм судлал) 60%-аас доош үнэлгээ авсан сурагч улирна.

Ахлах сургууль (9-12-р анги): Хичээл дээр 60%-аас доош үнэлгээ авсан сурагчийн хичээлийн кредитийг өгөхгүй. Америк сургуулийн ахлах сургуулийг амжилттай дүүргэхийн тулд сурагч 30 кредит бүхий хичээлийн кредит авсан, мөн олон нийтийн сайн дурын 40 цагийн ажилд хамрагдсан байхыг шаарддаг. Хичээлийн ирц мөн сургалтын чухал хэсэгт тооцогдоно. Хичээл

дээр шалтгаантай болон шалтгаангүйгээр 15 буюу түүнээс дээш хоногоор суугаагүй бол анги дэвшин суралцах, кредитээ дүүргэх зэрэгт муугаар нөлөөлнө.

Сургуулийн дараах нэмэлт хөтөлбөрүүд

Дунд, ахлах сургуулийн сурагчдад төрөл бүрийн сургуулийн дараах нэмэлт хөтөлбөрүүд, мөн хичээлийн давтлага зэргийг Даваа, Лхагва гарагуудын 3:30-4:25 цагийн хооронд явуулдаг. Эдгээр хөтөлбөрт хамрагдахын тулд сурагчид эцэг эхийн зөвшөөрлийг авсан байна.

Гэрийн даалгавар

Үзсэн хичээлээ бататгаж, ойлгосноо шалгах, амжилтаа ахиулах, түвшинг тодорхойлох зорилгоор сурагчдад гэрийн даалгаврыг өгнө. Эцэг эхчүүд хүүхдийнхээ даалгавраа хийж байгаа эсэхэд хяналт тавих хэрэгтэй. Хураалгасан даалгаврууд зөвхөн сурагчдын бие даан хийсэн даалгавар байх ёстой. Гэр бүлийн болон бусад шалтгаанаас үүдэн сурагч тодорхой хугацаагаар хичээлээс чөлөөлөгдөх үе гарна. Энэ тохиолдолд, багшийн ангид заасан хичээлүүдийг сурагч гэртээ бүрэн дүүрэн сурах боломжгүй, зааварчилгаа, дадлага зэргийг хийх боломжгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Чөлөө авсан сурагчийн явцыг багш яв цав тааварлах боломжгүй, гэрийн даалгаврыг урьдчилан бэлтгэх боломжгүй байдаг.

Ирцийн бодлого

Улаанбаатар дахь Америк Сургууль нь сурагч амжилттай суралцахын салшгүй нэг хэсэг бол сурагчийн ирц бөгөөд хичээлдээ тогтмол хамрагдах нь сурагчийн цаашдын сурах явцад шууд нөлөөлдөг гэдэгт итгэдэг. Хэрэв сурагч өвчний улмаас хичээлд суугаагүй бол эмчийн бичиг авчрах хэрэгтэй бөгөөд уг эмчийн бичиг дээр үндэслэн шалгалт/даалгаврыг нөхөн хийж болох эсэхийг шийднэ. Хичээл удаан хугацаагаар таслах нь сурлагад сөрөгөөр нөлөөлдөг. Хоцролт нь сурагчийн сурах явцад шууд нөлөөлж байгаа бол сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авч болно.

Хичээл таслалт

Сурагч хичээлдээ ирэх боломжгүй тохиолдолд эцэг эх энэ талаар сургуульд хичээл эхлэхээс өмнө, Сургалтын алба руу утсаар (11-348888) эсвэл имэйлээр (student_services@asu.edu.mn) мэдэгдэх хэрэгтэй.

Сурагч хичээлдээ эргэж ирснээ Сургалтын албанд бичгээр мэдэгдэнэ. Тухайн сурагчийн нэр, ангийг тодорхой тусгана.

Урьдчилан чөлөө авах

Сурагч урьдчилан чөлөө авч буй тохиолдолд эцэг эхээс шалтгааныг дурдаж, хичээлээс чөлөө өгөхийг хүссэн бичиг авчирна. Сургалтын албанаас хичээлийн ирцийг хянах үүднээс чөлөөний хуудас бөглүүлнэ. Уг хуудсыг сурагч багш нараар бөглүүлж, хичээл дуусахаас өмнө Сургалтын албанд авчирч өгсөн байна (Хавсралт А).

Зөвхөн багш нараар гарын үсэг зуруулсан хуудсанд үндэслэн сурагчид чөлөө өгөх тухай асуудлыг шийднэ. Урт хугацаагаар чөлөө авах бол Сургалт Хариуцсан Захирлын зөвшөөрлийг авах ёстой.

Гэрийн багш

Эцэг эхчүүд хүүхдийнхээ гэрийн даалгавар, хичээлд туслуулах зорилгоор гэрийн багш авах боломжтой. Гэвч гэрийн багш нь сурагчид өөр улс, өөр сургуулийн сургалтын хөтөлбөрөөр биш харин Улаанбаатар дахь Америк Сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр заахыг уриалж байна. Хичээлийн стандартыг хангах, амжилт гаргахад гэрийн багшийн үүрэг чухал. Эцэг эх та гэрийн багшид шаардлагатай мэдээллийг тухайн хичээл заадаг багшаас авна уу.

Гар утас, цахим хэрэгслүүд

Сурагчид сургууль дээр үнэтэй эд зүйлс авч ирэхийг хориглоно. Хэрэв авч ирсэн тохиолдолд өөрсдөө хариуцлага хүлээнэ. Гар утас болон бусад цахим хэрэгслүүдийг багшийн зөвшөөрөлгүйгээр ангид ашиглахыг хориглоно.

Дүрэмт хувцас

Сурагчийн хувцаслалтын дүрэм нь сургуулийн соёлын чухал хэсэг юм. Хувцаслалтын дүрмийг хичээлийн жилийн турш мөрдөнө. Сурагч дүрэмт хувцсыг Даваа гарагаас Пүрэв гараг хүртэл өмсөх дүрэмтэй. Сурагчдыг үсээ будахыг хориглоно. Сургууль дээр малгай өмсөхгүй.

2017-2018 оны хичээлийн жилд Америк сургуульд дараах дүрэмт хувцсыг өмсөнө. Үүнд:

- Цахилгаантай гадуур цамц
- Богино болон урт ханцуйтай поло цамц
- Хар өнгийн өмд, юбка
- Хар өнгийн хавар намар, өвлийн гутал, ботинк. Гутлан дээр өөр ямар нэг өнгө байж болохгүй.

****Сургуулийн дүрэмт хувцасны дүрмийг дагаагүй сурагчдыг гэр лүү нь буцаана**

Баасан гарагт энгийн хувцаслаж болно, дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй. Хэрэв сурагчийн энгийн хувцаслалт нь зүй зохисгүйд тооцогдох аваас гэр лүү нь буцаана. Дүрэмт хувцас болон хувцаслалтын дүрэмтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал Сургалтын Албанд хандана уу.

Яаралтай үед холбоо барих мэдээлэл

Сургуулиас хүүхдийн эцэг эх болон бусад холбогдох хүмүүстэй хичээлийн цагаар хэдийд ч холбоо барих боломжтой байх ёстой. Тиймээс эцэг эхүүд яаралтай холбоо барих утасны дугааруудыг сургуульд өгсөн байна. Дугаар өөрчлөгдсөн тохиолдолд сургуульд мэдэгдэж, солиулна.

Сурагчийг сургуулиас хасах

Тухайн сурагчийг сургах нь сурагч болон сургуулийн аль алины эрх ашигт нийцэхгүй байгаа тохиолдолд сурагчийг сургуулиас хасах эрхтэй. Тухайлбал, сурагчийн хүмүүжил бусад сурагчдын аюулгүй байдал, нэр төрд сөргөөр нөлөөлж байгаа бол, сургуулийн ёс зүй, үнэт зүйлд харшилж буй бол, сургуулиас тавьж буй хичээлийн ирц, сурлагын наад захын шаардлагыг хангахгүй бол сургуулиас хасна.

Сургуулийн хэмжээнд сурагчдад тавих зорилго

Улаанбаатар дахь Америк Сургууль нь хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүрэгтэйн хувьд дараах шаардлагыг хангасан сурагчийг төгсгөхийг зорино:

- Амжилттай суралцагч,
- Олон өнцгөөс хардаг,
- Идэвхтэй иргэн,
- Идэвхтэй харилцагч,
- Хувь хүний хөгжлийг эрхэмлэгч.

Сурагчийн шүүгээ

6-12 дугаар ангийн сурагчдыг хувцас, номоо хийх зорилгоор сургуулиас шүүгээ хуваарилна. Мөн сургуулиас шүүгээнд хэрэглэх цоож өгөх бөгөөд нууц дугаарыг бүртгэж авсан байна. Их хэмжээний мөнгө болон үнэтэй эд зүйлсийг сургууль дээр авчрах, шүүгээнд хадгалахгүй байх нь зүйтэй.

Эцэг эхийн сайн дурын оролцоо

Бид эцэг эхийн сайн дурын оролцоог үргэлж дэмжиж ажиллана.

Хориотой зүйлс

Сургууль дээр болон сургуулиас зохиогдож буй арга хэмжээний үеэр тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, өөрт болон бусдад аюул учруулж болзошгүй бусад зүйлсийг (зэвсэг, зэвсэг болгож ашиглаж болох зүйл) биедээ авч явах, хэрэглэх, худалдахыг хориглоно. Урьдчилан сэргийлэх үүднээс сургууль сурагчийн цүнх, шүүгээнд үзлэг хийх эрхтэй.

Мөн бусад сурагч, ажилчдын хувийн зөвшөөрөлгүйгээр зургийг нь авах, бичлэг хийхийг хориглоно.

Эцэг эхийн санал хүсэлт

Улаанбаатар дахь Америк Сургууль нь харилцан нээлттэй харилцааг эрхэмлэнэ. Эцэг эхийн санал хүсэлтийг дараах байдлаар хүлээн авна:

1. Хүүхдийнхээ багштай ярилцах
2. Хэрэв сэтгэл хангалуун бус бол Сургалт хариуцсан дэд захиралтай ярилцах
3. Дээрх уулзалтаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд Сургалт Хариуцсан захиралтай ярилцана. Сургалт хариуцсан захирал эцэслэн шийднэ.

Хичээлийн хэрэгсэл, ном

Сургуулиас сурагчдыг сурах бичгээр хангана. Сурах бичиг нь сургуулийн өмч бөгөөд цэвэрхэн хэрэглээд хичээлийн жилийн эцэст сургуульд буцаан өгнө. Номыг гадна хавтас нь харагдах, тунгалаг хавтсаар хавтаслана. Номоо хаяж гээгдүүлсэн тохиолдолд төлбөр төлнө. Сурагч сургуулиас шилжиж буй бол ном, шүүгээний цоожийг бүрэн хүлээлгэн өгсний дараа номын барьцаа мөнгөө бүтнээр буцаан авна.

Сургуулиас зохиох аялал

Сургуулиас зохиож буй аяллууд нь ангид сурсан зүйлээ бодит амьдралтай холбоход чухал ач холбогдолтой. Улаанбаатар дахь Америк Сургууль нь 2 удаагийн аяллын тээврийн хэрэгсэл, холбогдох (даатгал, шатахуун, зогсоол, орох хураамж болон автобусны жолоочийн цалин гэх мэт) зардлыг гаргана. Үүнээс гадуурх нэмэлт аяллын зардлыг эцэг эх гаргах ба шаардлагатай тохиолдолд хүүхэддээ өдрийн хоолыг нь бэлдэж явуулна. Сурагч аялалд явах, буцаж ирэхдээ сургуулийн унаагаар явна.

Сурагч төвтэй сургалтын орчин

Улаанбаатар дахь Америк Сургууль нь ирээдүйн удирдагчдыг бэлтгэн гаргах бөгөөд “Сур, Амжилт гарга, Манлайл” гэсэн уриан дор ажилладаг.

Бидний эрмэлзлэл :

- Хүүхдийн ашиг сонирхлыг дээдэлсэн сургалтын орчинг бүрдүүлэх
- Сургууль дээр халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх
- Сурагч бүрийн сурах арга барилыг хүндэтгэх
- Хүүхдийн асуудал шийдвэрлэх, сонголтоо зөв хийх, бүтээлч байх мөн өөрийгөө илэрхийлэх зэрэг чадварыг хөгжүүлэх
- Хүүхдийг ааш зан, оюуны болон нийгэмшлийн хувьд төлөвшүүлэх үүднээс эерэг дүр төрхийг бүрдүүлэх
- Эцэг эх, сургуулийн хамт олон, сурагчдад хүндэтгэлтэй хандах
- Өөрийн хийсэн үйлдлийн үр дагаврыг ухамсарлаж, хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээж чаддаг болгож сурагчдаа сургах
- Онол дадлага хосолсон сургалтын хөтөлбөрөөр хангах

Сурагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах журам

Сурагчийн сахилга батын хэм хэмжээ

Улаанбаатар дахь Америк сургууль нь сурагчид, багш нарт аливаа хүндрэлгүй сурах, багшлах таатай орчинг бүрдүүлдэг. Сурагчид дараах зүйлийг мөрдлөг болгоно.

1. Хичээлийн болон олон нийтийн арга хэмжээнд сургуулиас тогтоосон стандартыг мөрдүүлж, хэвшүүлэх
2. Сургуулиас чиглүүлсэн бодлогыг баримтлах
3. Аюулгүй орчинг бүрдүүлэх
4. Соёлын ялгаа, зан үйлийн уламжлалыг хүндэтгэн үзэх.

Улаанбаатар дахь Америк сургууль нь бие биенээ анхаарч халамжилдаг, бахархах зүйлтэй, сайн сайхан зүйлсийн төлөө тэмүүлдэг уур амьсгалд багш, ажилчид, сурагчид бүгд хамтдаа суралцаж, өсөж, хөгжиж байдгаараа онцлог юм. Бид сурагчдад сургуулийн орчинд хүндэтгэлтэй, хариуцлагатай, аюулгүй орчин бүрдүүлэн сахилга батыг чандлан сахих шаардлагыг тавьдаг. Энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь сурагчдыг дэг журамтай, тодорхой зорилготой болгох нөхцөлийг бүрдүүлж, ирээдүйн манлайлагч иргэн бэлдэхэд чухал ач холбогдолтой.

Сурагчид дараах журмыг хатуу мөрдөнө:

- Бусдын болон өөрийн эрх, өмч, аюулгүй байдалд хүндэтгэлтэй хандана.
- Соёлтой үг хэллэг хэрэглэх, ёс зүйтэй өөрийгөө илэрхийлнэ.
- Бусдыг тохуурхах, доромжлох, хүч хэрэглэх, ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрээс ангид байна.
- Сургуулийн хувцаслалтын дүрмийг сахина.
- Хичээл, дугуйлан, арга хэмжээнд идэвхтэй оролцох, цаг барьж, бэлтгэлтэй оролцоно.
- Сургууль дээр бусдын эрхэнд хүндэтгэлтэй хандана.
- Сургуулийн болон бусдын эд хөрөнгөнд хүндэтгэлтэй хандана.
- Дэг журамтай, эерэг, аюулгүй сурах орчинг бүрдүүлэх хэмжээнд биеэ авч явна

Дараахи тохиолдолд сурагчийг хичээлээс түр түтгэлзүүлнэ:

- Бусдын биед ноцтой гэмтэл учруулахаар үйлдэл хийх
- Шалгалт/ тестийн үеэр хуулах, хуурах
- Зөвшөөрөлгүйгээр сургуулиас гарч явах
- Сургуулийн эд хөрөнгийг эвдэн сүйтгэх
- Багш болон дээд тушаалын хүнтэй бүдүүлэг үг хэллэг, хараал хэрэглэх
- Хулгай дээрэм хийх
- Бусдын биед зүй бусаар хүрэх
- Зодолдох
- Дээрэлхэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх
- Сургуулийн нэр хүндийг сэвтгэх
- Зөрүүдлэх

Эдгээр шалтгааны улмаас хичээлээс түр түтгэлзүүлсэн сурагчийг эцэг эхтэй нь уулзаж ярилцсны дараа хичээлд буцаан суух зөвшөөрөл өгнө.

Сургалтын албаны ажилтан

Сургалтын албаны ажилтнууд сурагчийн эцэг эхтэй уулзалтын цаг тохирох, шаардлагатай үед орчуулга хийнэ.

Технологи, Интернет хэрэглээ

- Сургуулийн компьютерийг зөвхөн хичээлийн зорилгоор ашиглана
- Сурагч номын сан болон компьютерийн лабораторийн компьютер дээр зөвшөөрөлгүйгээр программ суулгах болон устгахыг хориглоно.

Сургуулиас гарах

Сурагч сургуулиас гарч буй бол эцэг эх/асран хамгаалагч Сургалтын Албанд бичгээр хүсэлт тавина. Шаардлагатай бүх ном материалыг буцаан өгсний дараа төлбөрийн буцаалтыг хийнэ. Эцэг эхийн хүсэлтийн дагуу сурагч хичээл ордог бүх багшаар тойрох хуудсанд гарын үсэг зуруулан, сургалтын албанд буцаан өгнө.

Сургуулийн автобусны журам

Улаанбаатар дахь Америк дунд сургуулийн сурагчдад автобусны төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ. Энэ үйлчилгээг хүн тээврийн үйлчилгээний зөвшөөрөлтэй, техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгт тэнцсэн, шаардлагад нийцсэн автобусны компаниудын дунд тендер шалгаруулж, тэнцсэн байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. Автосны жолоочид тусгай шаардлага тавьж ажиллана.

1. Сургуулийн үүрэг

1.1 Автобусаар үйлчлүүлж байгаа хүүхдийг сургуулийн захиргаанаас хүн томилж, хянаж ажиллуулдаг байсныг зогсоож, 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн камер, чанга яригч бүхий автобусаар үйлчилгээ үзүүлнэ. Харин автобусны жолооч нарыг эцэг эхтэй холбоо барих гар утасыг сургуулиас хангана. Мөн эцэг эхийн утасны жагсаалтыг өгнө.

1.2 Эцэг эх автобусны маршруттай танилцсаны дараа тухай үйлчилгээг авах гэрээг байгуулна. Гэрээ байгуулах ажлыг автобусны үйлчилгээ эхлэхээс 2 долоо хоногийн өмнө хийнэ. Гэрээ байгуулж, төлбөр төлснөөр тухайн сурагчийн автобусны суудал баталгаажна. Үүний дараа сурагчдын нэрсийг жолоочид хүргүүлнэ.

1.3 Хэрэв тухайн маршрутын автобусны суудал дүүрсэн тохиолдолд дараагийн автобусыг нэмж захиалж болно. Ингэхдээ автобусны суудлын 70 хувийг дүүргэсэн тохиолдолд шинээр автобус захиалах ажлыг сургуулийн захиргаа хийнэ.

1.4 Автобусны жолоочид тавих тусгай шаардлагыг эцэг эхэд танилцуулах, эцэг эх, жолоочийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэхэд сургуулийн захиргаа туслалцаа үзүүлнэ.

1.5 Сургуулийн захиргаанаас сард нэг удаа автобусны жолоочид тавьж буй шаардлагын биелэлтэнд гэнэтийн шалгалт хийнэ. Хяналтаар илэрсэн дутагдлыг арилгах санаачлагыг автобусны компанитай хамтарч шийдвэрлэнэ.

1.6 Автобусны үйлчилгээний үндсэн маршрутыг өөрчлөх, шинэ хүүхдийг шинэ хорооллоос авах зэрэг асуудлыг сургуулийн захиргаатай хамтарч шийдвэрлэнэ. Ингэхдээ зөвхөн асфальтан болон бетон хучилттай, баталгаатай замаар хүүхэд тээвэрлэх бодлогыг тууштай баримтална.

1.7 Автобусанд суух хүүхдийн насны доод хязгаар нь 6 нас (1-р ангийн сурагч) байна. Харин, заасан хязгаараас доош насны хүүхдийг нэг гэр бүлийн ах эгч нар нь харгалзаж явахыг эцэг эхээс албан бичгээр зөвшөөрсөн тохиолдолд үйлчилгээнд хамруулж болно.

1.8 Автобусны үйлчилгээний журмын 3.1, 3.2, 3.4 болон 3.5-ийг зөрчсөн сурагчдын автобусны үйлчилгээ авах эрхийн асуудлыг сургуулийн захиргаа хэлэлцэх үүрэгтэй. Хэрэв дээрх зөрчлийг удаа дараа гаргасан тохиолдолд сургуулийн захиргаа өөрийн санаачлагаар автобусны гэрээг хүчингүй болгох эрхтэй.

1.9 Сургуулийн захиргаа жилд хоёр удаа автобусны жолооч нарыг үйлчилгээний соёлын сургалтанд хамруулна.

1.10 Автобусны техникийн гэмтэл, жолоочийн буруутай үйлдлийн улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болвол хүүхэд тээвэрлэх үйлчилгээ үзүүлж чадаагүй хохирлыг автобус компанид тавьж, барагдуулах ажлыг сургууль хариуцна.

2. Эцэг эхийн үүрэг

2.1 Эцэг эхчүүд хүүхэддээ автобусан дотор биеэ зөв авч явах зааварчилгааг өгсөн байна. Маршрутанд заасан зогсоол дээр хүүхдээ 5 минутын өмнө ирүүлсэн байх үүрэгтэй.

2.2 Бага насны хүүхдийг зогсоол дээр хүргэж өгөх, тосож авах ажлыг эцэг эх хариуцна. Хэрэв энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд, жолооч тухайн хүүхдийг сургууль дээр буцаан авчирна. Эцэг эх хүүхдээ сургуулийн харуул дээрээс ирж авна.

2.3 Хэрэв хүүхэд өвдсөн болон бусад шалтгаанаар автобусаар үйлчлүүлэхгүй тохиолдолд эцэг эхчүүд өмнөх өдөр эсвэл өглөө эрт жолоочид мэдэгдэх ёстой.

2.4 Сурагч товолсон цагт зогсоол дээр гарч ирээгүйн улмаас автобусанд сууж чадаагүй тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ өөрсдөө сургуульд хүргэж өгнө. Энэ тохиолдолд автобусны үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй.

2.5 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас автобус цагаасаа 15 минутаар хоцорсон тохиолдолд эцэг эх хүүхдээ сургуульд хүргэж өгөх үүрэгтэй. /хальтаргаа, гулгаа, цас мөс, салхи шуурга, усан мөндөр зэрэг замын хөдөлгөөнд харшлах нөхцлүүдийг давагдашгүй хүчин зүйлд тооцно./

2.6 Хэрэв нэгэнт байгуулсан автобусны гэрээг цуцлах тохиолдол үүсвэл эцэг эх сургуулийн захиргаанд бичгээр албан ёсоор мэдэгдэнэ. Энэ тохиолдолд төлбөрийн буцаалтыг сургуулиас батлагдсан журмын дагуу шийдвэрлэнэ.

3. Сурагчийн үүрэг

3.1 Сурагч автобус хөдлөхөөс өмнө суудлаа эзэлж, аюулгүйн бүсийг зүүсэн байна. Автобус зогсоол дээр бүрэн зоссны дараа сурагч суух/буух үйлдлийг хийнэ.

3.2 Сурагч өглөө автобусны зогсоол дээр 5 минутын өмнө ирсэн байна. Орой хичээл тарсны дараа автобусанд 5 минутын өмнө суусан байна.

3.3 Сурагч зөвхөн сургууль дээр бууж, гэртээ харих тогтсон маршрутаар, заасан зогсоол дээр бууна. Сурагч өөр хүсэлт жолоочид тавих эрхгүй. Сурагч автобуснаас буугаад зам хөндлөн гардаг бол автобусны араас 3 метрийн зай барьж, гарцаар гарна.

3.4 Сурагчид хоорондоо нам дуугаар ярилцаж, зөв боловсон үг яриа хэрэглэнэ. Сурагч биеэ зөв зохистой авч явж, бусадтай хүндэтгэлтэй харьцана. Хэрэв хүндэтгэлгүй харьцсан бол уучлалт гуйх үүрэгтэй.

3.5 Автобусанд болсон аливаа маргаан, зохисгүй үйлдлийг хоёр тал зөвөөр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд автобусны камерийн бичлэг дээр үндэслэн шийдвэрлэнэ.

3.6 Сурагч автобусанд юм идэх, уух, хувцас солих, амьтан авч явах, шовх, хурц иртэй, хагарамтгай зүйлсийг биедээ авч явах, мөн автобусны үйлчилгээ аваагүй найз нөхдөө

дагуулж явахыг хориглоно.

4. Жолоочийн үүрэг

4.1 Жолооч автобусанд суурилуулсан чанга яригч болон камерийг байнгын ажиллагаатай байлгана. Хүүхдийн гар толгойг цонхоор чөлөөтэй гаргахгүй, нүүрэнд нар шууд тусахгүй байх хамгаалалтыг автобусанд хийсэн байна.

4.2 Автобусны суудлын бүрээс, суудлын дэр, шал, цонх, бариул, хана, хаалга тааз зэрэг эд ангийг бүрэн бүтэн бөгөөд, цэвэрхэн байлгах үүрэгтэй. Жолооч өөрөө хувийн ариун цэвэр сахисан байна. Өвлийн улиралд автобусны дотор дулаан байлгах ба автобусан дотор утаа, угаар гаргахгүй.

4.3 Жолооч сурагчидтай зөв зохистой харицана. Сурагчдыг буух/суух, зогсоол дөхөж байгааг чанга яригчаар мэдэгдэх, мөн унтсан хүүхдийг сэрээж зогсоолд нь буулгах үүрэгтэй. Хэрэв сурагч цагтаа зогсоол дээрээ ирээгүйн улмаас автобусанд суугаагүй бол эцэг эхэд нь мэдэгдэнэ.

4.4 Жолооч сургуулиас өгсөн хүүхдийн нэрсээр, тогтоосон маршрутаар, тогтсон цагт хүүхдийг буулгах үүрэгтэй. Жолооч хүүхдийн болон эцэг эхийн хүсэлтээр маршрутаас хазайх, байр орцны үүднээс очиж авах/буулгахыг хориглоно.

4.5 Автобусны үйлчилгээний асуудлаар тавьж буй эцэг эхийн санал хүсэлтийг сургуулийн захиргаанд уламжлах үүрэгтэй. Харин дур мэдэн шийдвэр гаргахыг хориглоно.

4.6 Хэрвээ сургуулийн захиргаанаас жолоочид ажлаа сайжруулах үүрэг өгөгдсөн бол тодорхой хугацаа өгч, хамтран ажиллана.

4.7 Хэрэв жолоочтой холбоотой асуудлаар эцэг эхээс гомдол санал ирвэл сургуулийн захиргаа жолоочийг байлцуулан хамтарч, шийдлийг олж ажиллана. Жолооч энэ үед уян хатан, тэвчээртэй хандахыг эрхэм болгоно.

4.8 Жолооч ажлын байранд архи тамхи үнэртүүлэх, ёс бус үг хэллэг хэрэглэх, эцэг эхтэй зохисгүй харьцах, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох, өөрт хамааралгүй асуудалд ач холбогдол өгөх, дур мэдэн маршрут солих, цагаа барихгүй хүүхэд эцэг эхэд төвөг удах, бусдын эрх ашгийг үл хүндэтгэх, автобусанд хоол идэх, найз нөхдөө автобусандаа суулгах, дагуулах, хүлээлтийн цаг ашиглаж тамхи татах, эрсдэлтэй жолоочийн болон замын хөдөлгөөний үйлдэл хийхийг хориглоно.

Улаанбаатар Дахь Америк Сургууль Тамирчдын Эрхэм Зорилго

Америк сургуулийн биеийн тамирын танхимын эрхэм зорилго нь сурагч бүр спортоор хичээллэснээр багаар ажиллах, өрсөлдөх чадвартай, өөрийгөө дайчлах, үнэнч шударга тоглох, улмаар оюун санаа, бие бялдар, сэтгэлзүйн хаттай иргэн болж төлөвшихөд нь сурагчдыг хөгжүүлэхэд оршино.

1. Хөтөлбөрүүд

- 1.1. Дунд ахлах сургуулийн сурагчдын холын зайн гүйлт, Хавар, намрын улирал
- 1.2. Дунд, ахлах сургуулийн охид, хөвгүүдийн бөхийн дугуйлан. Одоогоор туршилтын журмаар энэхүү дугуйланг хичээллүүлэх бөгөөд, 2016-2017 оны хичээлийн жилийн эцэст үнэлгээ өгнө.
- 1.3. Дунд сургуулийн сурагчдын спорт
 - 1.3.1. Хөл бөмбөг, намар
 - 1.3.2. Сагсан бөмбөг, өвөл
 - 1.3.3. Гар бөмбөг, хавар
- 1.4. Ахлах сургуулийн сурагчдын спорт
 - 1.4.1. Хөл бөмбөг, намар
 - 1.4.2. Сагсан бөмбөг, хавар
 - 1.4.3. Гар бөмбөг, хавар
- 1.5. А.С.А.М.И.С тэмцээн
 - 1.5.1. Улаанбаатар дахь Америк Сургууль нь Хятад, Монгол улсын олон улсын сургуулиудын лигийн гишүүн бөгөөд Хятад улс руу Гар бөмбөг, хөл бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнд оролцохоор аялдаг. Сургуулийг төлөөлөн сурагч, тамирчдыг сонгон оролцуулдаг. Багийн гишүүнээр сонгогдсон сурагчид аяллын зардлыг өөрсдөө төлөх бөгөөд Биеийн Тамирын танхимын эрхлэгчийн заасан хугацаанд зохих төлбөрийг гүйцэтгэхийг шаардана.

2. Багт орох шалгуурууд

2.1. Нас

- 2.1.1. Ахлах сургуулийн сурагчид нь 15-аас дээш настай, 9-12 ангийн сурагч байх. Гэхдээ, тухайн сурагчийн бие даалт, сурлага, бие бялдрын хөгжил болон бусад хүчин зүйлсийг харгалзан сонгоно.
- 2.1.2. Дунд сургуулийн тамирчин 6-8-р ангийн сурагч байна.

2.2. Дүн

Тамирчид бүх хичээл дээрээ 60%-с дээш дүнтэй байхыг шаардах бөгөөд хэрвээ аль нэг хичээл дээр 60%-с доош дүнтэй байвал багт оруулахгүй, гэхдээ тухайн сурагч хичээлдээ ахиц гаргаж, ирцийн таслалтгүй байгаа тохиолдолд туршилтын хугацаагаар багт оруулна

2.3. Ирц

- 2.3.1. Тухайн багт гишүүнээр орохын тулд сурагч хичээлдээ тогтмол явах, идэвхтэй сайн суралцахыг шаардана. Хичээлд тогтмол хоцордог, 15-аас дээш өдөр хичээлд суугаагүй сурагчийг багаас гаргана.

2.3.2. Тэмцээний улирлын үеэр сургуулиас чөлөө авах, хичээл тасалсан тамирчдыг багийн бэлтгэлд оруулах, мөн аялан тоглох тэмцээнд оруулахгүй хүртэл арга хэмжээ авна.

2.3.3. А.С.А.М.И.С дүрмийн дагуу, аливаа спортоос нэг жил хүртэл хугацаанд чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

2.4. Тоглогч сонгох

2.4.1. Багт оролцох хүсэлтэй сурагчид шалгаруулалт хийх өдөр ирсэн байх ёстой. Багийн тамирчид ямар шаардлага хангасан байхыг танилцуулна. Тэдгээр шалгууруудыг хангах нь тухайн тамирчин-сурагчийн үүрэг юм. Тухайн багт сонгогдоогүй сурагчид бусад спортын төрөл эсвэл хичээлээс гадуурх дугуйланд хамрагдах боломжтой

Ёс зүйн хэм хэмжээ

2.5. Сахилга бат

2.5.1. Бүх тамирчин сурагчид дараахи сахилга батын хэм хэмжээг мөрдөнө.

2.5.2. Бусад тоглогчид болон дасгалжуулагч нарт шударга хүндэтгэлтэй хандана.

2.5.3. Дүрмийн дагуу тоглоно.

2.5.4. Өөрийгөө хянах чадвартай байх, бүдүүлэг үг яриа хэрэглэхгүй.

2.5.5. Англиар ярина.

2.5.6. Багийн тоглогч байж багтайгаа хамтарч тоглоно.

2.5.7. Өмнө нь ямар нэгэн байдлаар хүмүүжлийн доголдол гаргасан тохиолдолд (анги танхимдаа, спортын зааланд, сургуулийн коридорт болон хоолны газарт) сахилга батын гэрээ хийх шаарлагатай.

2.6. Дасгалжуулагчийн сахилга бат

2.6.1. Бүх дасгалжуулагчид дараах дүрмийг мөрдөнө.

2.6.2. Тоглогчид, шүүгч, бусад дасгалжуулагч нартай шударга, хүндэтгэлтэйгээр хандах

2.6.3. Сурагчдыг англиар ярихыг дэмжих

2.6.4. Өөрийгөө хянах чадвартай, бүдүүлэг үг яриа хэрэглэхгүй

2.7. Тамирчны ёс зүй

2.7.1. Шударга тоглож, шударга ялж, ялагдахыг заах нь УАС-ын спортын хөтөлбөрийн нэг чухал хэсэг юм. Тиймд сурагчид тамирчин хүнд байвал зохих чадваруудад суралцах шаардлагатай. Сөрөг үг хэлэх, хандлага гаргах, сэтгэл хөдлөл илэрхийлэх зэрэг орно.

2.8. Дундаас нь хаях

2.8.1. Багаа дундаас нь хаясан сурагчид тухайн хичээлийн жилд дахин багт орох эрхгүй болдог. Багт сонгогдсноор тухайн сурагч өөр бусад сурагчдын орон тоог авсан гэдгээ ухамсарлах хэрэгтэй. Мөн багийн гишүүн байна гэдэг нь бусад гишүүдийн хичээл зүтгэл, оролцоо мөн дүрмийг дагах нь тухайн сурагчаас хамааралтай гэдгийг санах хэрэгтэй.

2.9. Өөрийгөө дайчлах

2.9.1. Багийн тамирчин бүр

2.9.1.1. Багийн бүх тоглолтонд өөрийгөө дайчлах, бэлтгэл, дадлага, бусад сургуулиуд дээр хийх тоглолт, уулзалтанд оролцох

2.9.1.2. Багийн идэвхтэй тоглогч, сургуулийн нэг хэсэг байхын төлөө өөрийгөө дайчлах

2.9.1.3. Тамирчны ур чадвараа байнга сайжруулах

2.9.1.4. Багийн тоглолтонд өөрийгөө болон бусад гишүүдээр бахархах

2.10. Тээвэрлэлт

2.10.1. Хол ойроос үл шалтгаалан аливаа спортын арга хэмжээнд шаардлагатай тээврийн хэрэгслийг сургуулиас зохион байгуулна. Сурагч өөр унаагаар зорчих тохиолдолд эцэг эхийн гарын үсэг бүхий зөвшөөрлийн бичгийг дасгалжуулагч болон спорт хариуцсан багшдаа өгөх ёстой.

Хувцаслалт, хэрэгсэл

2.11. Сурагчид бэлтгэлд өөрсдийн хувцсыг өмсөнө. Тэмцээнд өмсөх хувцсыг сургуулиас хангана.

2.12. Сургууль спортын шаардлагатай тоног хэрэгслээр хангана.

2.13. Спортын улирлын сүүлийн долоо хоногт багтаж сурагч сургуулиас өгсөн хувцас, тоног хэрэгслийг угааж цэвэрлэн буцаана.

Эрсдэл

2.14. Тамирчин сурагч нь спортын багийн шалгаруулалт, бэлтгэл, өрсөлдөөн, тоглолт, тэмцээний үеэр бэртэх магадлалтайг сайтар ухамсарлах хэрэгтэй. Мөн сурагч эрүүл мэнд, бэртэлтэй холбоотой байвал дасгалжуулагч, спорт хариуцсан багшид мэдэгдсэн байна. Сурагч бие бялдарын хувьд багтаа идэвхтэй тоглох чадвартай байх шаардлагатай.

2.15. Спортын арга хэмжээ, бэлтгэлийн үеэр гэмтэж бэртсэн тохиолдолд энэ талаар дасгалжуулагч, спорт хариуцсан багшид яаралтай мэдэгдэнэ. Гэмтэл бэртлийн дараа аливаа спортын арга хэмжээнд дахин оролцох эрхийг эмчийн бичиг дээр үндэслэн олгоно.

Гарын үсэг

Тамирчны гарын үсэг: _____ Спортын төрөл: _____

Овог нэр (Дармалаар бичих): _____

Эцэг эхийн гарын үсэг: _____ Он сар өдөр: _____

Овог нэр (Дармалаар бичих): _____

ХАВСРАЛТ А:

Сургуулиас чөлөө авах маягт – Дунд сургууль

ХЭРЭВ СУРГУУЛИЙН ДҮРЭМД ЗӨВШӨӨРСНӨӨС УРТ ХУГАЦААГААР ЧӨЛӨӨ АВАХ ТОХИОЛДОЛД, СУРАГЧ ТАСАЛСАН ХУГАЦААНД ЗААСАН СЭДВЭЭР ШАЛГАЛТ ӨГСНИЙ ДАРАА ТУХАЙН ХИЧЭЭЛИЙН КРЕДИТИЙГ ӨГНӨ.

Чөлөө авах шалтгаан

Сурагчийн нэр: _____

Анги: _____

Багш: _____

Чөлөөний шалтгаан: Өвчин, эрүүл мэнд Гэр бүлийн асуудал
 Ар гэрийн шалтгаан Бусад: _____

Чөлөө авах хугацаа: _____ (аас) _____ (хүртэл)

Чөлөөтэй хугацаанд хичээлээ хэрхэн нөхөх/нэмэлт мэдээлэл: _____

(Чөлөө авах дээд хугацаа 15 өдөр байна)

Эцэг эх, асран хамгаалагчийн мэдээлэл

Утас: _____ Гар утас: _____

Имэйл: _____

Гарын үсэг: _____ Огноо: _____

Зөвшөөрсөн Сургуулийн захиргааны ажилтан, багш

Зөвшөөрсөн Татгалзсан
Захирал: _____
Гарын үсэг _____ Огноо _____

Сургалтын алба багш руу имэйлээр мэдэгдсэн эсэх Тийм Үгүй

ХАВСРАЛТ Б:

НИЙГМИЙН СҮЛЖЭЭ (СОШИАЛ МЕДИА)

АШИГЛАХ УДИРДАМЖ

Сургуулийн ажилтан, албан хаагчид, багш, сурагчид болон эцэг эхчүүд нийгмийн сүлжээ болон интернет аппликейшнийг ашиглахдаа энэхүү удирдамжийг баримтална

Америк Сургуулийн медиа бодлого нь ажилчдыг төрөл бүрийн онлайн арга хэмжээнд идэвхитэй оролцохыг уриалдаг. Гэхдээ, хувь хүний хийсэн үйлдэл Америк сургуулийн нэр хүндтэй шууд хамааралтай тул хариуцлагатай байх нь ихээхэн чухал.

Ажилчид нийгмийн сүлжээг ашиглах нь: Сурагчдын аюулгүй байдлыг нэн түрүүнд тавих бодлого

Нийгмийн сүлжээнд хувийн болон албаны харилцаа холбоо алдагдах нь их байдаг тул Америк сургуулийн ажилчид, багш нар интернетийн орчинд мэргэжлийн ёсзүйг байнга баримталж байх ёстой. Түүнчлэн, нийгмийн сүлжээгээр ёс бус авир гаргахгүй байхыг санах хэрэгтэй.

Америк сургууль нь олон нийтэд хүртээмжтэй мэдээлэл цацах үүднээс нийгмийн сүлжээг ашигладаг. Ингэснээр манай сургуулийн талаарх мэдээллийг бусад хүмүүс олон нийтэд хуваалцах боломжийг нээж өгдөг. Сургуулийн Фэйсбүүк хуудсанд нэгдсэн хүмүүс манай сургуулийн талаарх мэдээллийг байнга авах боломжтой. Түүнээс гадна, бусад оролцогч талууд болох шинээр элсэн сурах сурагчид, эцэг эхчүүд, бусад хандивлагч нартай харилцаа холбоо үүсгэх боломжийг нээж өгдөг.

Сургалт хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирлын зөвшөөрөлгүйгээр ажилчид сургуулийн логог ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

Сурагчдынхаа аюулгүй байдлыг хангах үүднээс, Сургуулийн ажилчид нийгмийн сүлжээг ашиглахдаа дараах зүйлсийг байнга санаж байх хэрэгтэй:

- Бусад хүмүүсийг автоматаар тэмдэглэхгүй байх** (таны нийтэлсэн зураг, мэдээлэлд бусад хүмүүсийг автоматаар таниулж, тэмдэглэх).
- Газарзүйн байршлыг тэмдэглэхгүй байх** (нийтэлж буй мэдээлэлд газарзүйн байршлыг тэмдэглэх. Энэ нь тухайн байршлыг өргөрөг, уртраг, газарзүйн байршлын нэр, зай, өндөрлөг зэрэг мэдээллийг агуулдаг)
- Овгийн нэрийг хэрэглэхгүй байх** (зөвхөн өөрийн нэрийг, овгийн эхний үсэгтэй бичих).
- Нууцлалыг байнга хадгалах.** Гэр бүлээр авхуулсан зураг, бичлэгийг хэзээч олон нийтийн сүлжээгээр цацахгүй байх. Сургуулийн өмч, эсвэл нууцлалтай холбоотой аливаа мэдээллийг сургуулийн ажилчид нийтлэхгүй байх

❑ **Ил тод байх:** Сурагчид болон тэдний гэр бүлтэй ойр дотно харилцаа үүсгэсэн тохиолдолд, тухайн сурагчийн гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагсдын хувьд та Америк сургуулийг төлөөлж байгаа гэдгээ байнга санах.

❑ **Эцэг эхэд мэдээлэх:** Сурагчдыг нийгмийн сүлжээ, аппликэйшн ашиглах төсөлт ажилд оролцож байгаа мэдээллийг багш нар сурагчдын эцэг эхэд урьдчилан мэдээлэх хэрэгтэй.

Америк сургуулийн хамт олны бодлого: Интернет нийтлэл, нийгмийн сүлжээн дэх хувь хүний хариуцлага

❑ Багш, сурагчдын онлайнаар харилцах бүх харилцаа зөвхөн хичээл, сургууль, эсвэл сургуультай холбоотой бусад арга хэмжээтэй холбоотой байх

❑ Нийгмийн сүлжээ ашигладаг Сургуулийн ажилчид сурагчдын хувийн нууцлалтай холбоотой ямар нэгэн мэдээллийг, зургийг зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй, нийтлэхгүй байх

❑ Сургуулийн хамт олны овгийн нэр, хаяг, имэйл хаяг, утасны дугаар зэргийг олон нийтийн сүлжээгээр нийтлэхгүй байх

❑ Бусадтай нүүр нүүр харан харилцаж байгаатай нэгэн адил онлайнаар ч мөн адил ёсзүй, хүндлэл, үнэнч шударгыг эрхэм болгох

Америк сургуулийн хамт олны бодлого: Эцэг эхчүүдийн нийгмийн сүлжээ хэрэглээ

Нэг ангийн сурагчдын дундах онлайн харилцаа, бусад нийгмийн сүлжээний хэрэглээ нь сурагчид, эцэг эх, багш нар өөр хоорондоо харилцах хүчирхэг хэрэгсэл юм. Ийм төрлийн харилцаа холбоо нь сурах боломжийг нээж өгдөг сайн талтай. Тиймээс эцэг эхчүүдийг нийгмийн сүлжээн дэх сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зөв зохистой саналаа оруулахыг хүсэж байна

Нийгмийн сүлжээг ашиглахдаа Америк Сургуулийн эцэг эхчүүд дараах журмыг мөрдлөгө болгоно:

❑ Хүүхдээ аливаа онлайн хэлбэрийн төсөлт ажилд оролцохын өмнө эцэг эхчүүд багш нартай нь холбоо барина.

❑ Эцэг эхчүүд онлайн хичээлийн мэдээллийг хууль бус зорилгоор, буруугаар ашиглахыг хориглоно

❑ Нийгмийн сүлжээн дэх төсөлт ажлын мэдээллийг эцэг эхчүүд байнга уншиж, шаардлагатай үед оролцох ёстой

❑ Америк сургуулийн бусад сурагчдын хувийн мэдээллийг эцэг эхчүүд бусдад түгээх, нийтлэхийг хатуу хориглоно

❑ Онлайн хичээлтэй холбоотой, төсөлт ажлуудын талаар хамгийн түрүүн тухайн хичээлийн багштай холбоо барих.

ХАВСРАЛТ В:

СУРАГЧИЙН ГЭРЭЛ ЗУРАГ, ВИДЕО БИЧЛЭГ АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Сургуулийн вэбсайт дээр ашиглах зураг, видео бичлэг

Бид сурагчдынхаа аюулгүй байдал, хувийн мэдээллийг хамгаалах үүднээс сургуулийн вэбсайт дээр хатуу дүрэм баримдалдаг. Сурагчдын аюулгүй байдлыг хамгаалахын тулд бид тэдний овог, нэрийг вэбсайт дээр тавьдаггүй.

___ Тийм, миний хүүхдийн зураг, видео бичлэгийг сургуулийн вэбсайт дээр ашиглахийг би зөвшөөрч байна.

___ Үгүй, миний хүүхдийн зураг, видео бичлэгийг сургуулийн вэбсайт дээр ашиглахийг би зөвшөөрөхгүй байна.

Олон нийтийн харилцаанд ашиглагдах зураг болон видео бичлэг

Зарим тохиолдолд олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах үед сурагчдын зураг болон видео бичлэгийг ашиглах тохиолдол гардаг. Мөн сонин сэтгүүл, сургуулийн сурталчилгаа болон гарын авлага зэрэгт ашиглагдан нийтийн хэвлэлд гардаг.

Хүүхдийн аюулгүй байдал нэн тэргүүнд тавигдах учраас нийтлэгдэхээс өмнө мэдээллийн агуулгыг багш, ажилчид сайтар шалгадаг. Олон нийтийн хэвлэлд гарч байгаа зураг, бичлэг дээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сурагчдын нэрийг овоггүйгээр нь ашигладаг. Сургуулийн зүгээс хүүхдийн овог нэрийг ямар ч тохиолдолд бүтнээр нь олон нийтэд түгээж хэвлэхгүй.

___ Тийм, миний хүүхдийн зураг болон видео бичлэгийг олон нийтийн харилцаатай холбоотой материал дээр тавихыг би зөвшөөрч байна.

___ Үгүй, миний хүүхдийн зураг болон видео бичлэгийг олон нийтийн харилцаатай холбоотой материал дээр ашиглахийг би зөвшөөрөхгүй байна.

Сурагчийн нэр: _____ Анги: _____

Эцэг эх/асран хамгаалагчын гарын үсэг: _____

Он сар өдөр: _____

SECONDARY SCHOOL STUDENT CHECKOUT FORM
2017-2018 School Year

Student's name: _____ Grade: _____

Current academic year: _____

REASON: (1) ___ GRADUATION Class of: _____
(2) ___ WITHDRAWAL Effective Date: _____

To be filled in and circulated by the subject teachers. Please write your name and signature AFTER a student returns all books and other material back to you.

SUBJECT	TEACHER'S NAME	TEACHER'S SIGNATURE
English		
Math		
Social Studies		
Geography		
History		
Science		
Chemistry		
Physics		
Biology		
Guidance and Career Studies		
PE and Health		
Visual Arts		
Drama/Dance		
Music		
ESL		
Mongolian		
Chinese/French		
Computer Science		
Business		

_____ **Homeroom Teacher (to be completed once all subject teachers have been signed):**
(Subject Name)

_____ All books and other materials returned

_____ Lock returned

Homeroom teacher's name: _____ Signature: _____

Library:

_____ All borrowed materials returned

_____ Fee to be refunded for damaged or lost books MNT/\$ _____

Librarian's name: _____ Signature: _____

Student Services:

_____ Letter of student withdrawal (Date received: _____)

_____ Copy of records given: (_____)

_____ Appropriate refunds made (Explanation: _____)

Student Services Office: Name _____ Signature: _____

Accountant:

Fees and other charges have been paid:

Refund calculation:

_____ Re- Registration

Tuition fee refund: _____

Tuition: _____ 1st Semester _____ 2nd Semester

Book deposit refund: _____

_____ Bus _____ Library fee (\$ _____)

Bus payment refund: _____

Cap and Gown: _____ Deposit _____ Bought

Library fee: _____

Justification of other refunds: _____

Other fee 1: _____

Total refund:

Accountant's name: _____ Signature: _____